МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 30 өдөр Дугаар А/201 Мөрөн сум

Аймгийн бүсийн хурдан морины уралдааныг
товлон зарлах, зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2,17.1.4, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, Биеийн тамир спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөвсгөл аймгийн Морин спорт уяачдын холбооны саналыг үндэслэн аймгийн хэмжээнд 2024 онд зохион байгуулагдах хаврын болон зуны хурдан морины аймгийн бүсийн уралдааны хуваарийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2.Аймгийн төв Мөрөн суманд зохион байгуулагдах хаврын бүсийн уралдааныг зохион байгуулах чиг үүрэг бүхий комиссыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3.Аймгийн бүсийн хурдан морины уралдааныг зохион байгуулахдаа хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах ажлыг зохион байгуулагчийн зүгээс онцгой анхаарч холбогдох байгууллагаас ирүүлсэн зөвлөмж, чиглэлийг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Цагдаагийн газрын дарга хурандаа (А.Алтанцоож), Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын газрын дарга (Ч.Дашбаяр), холбогдох сумдын Засаг дарга нарт, аймгийн Морин Спорт Уяачдын Холбоо, сумдын салбар холбооны удирдлагуудад тус тус үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатарт)-д даалгасугай.

ДАРГА П.ЛХАГВАЖАВ

Захирамж2024

6712010624

Аймгийн Засаг даргын 2024 оны
04 дүгээр сарын 30-ны өдрийн А/201 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

Аймгийн хэмжээнд 2024 онд зохион байгуулагдах хаврын болон зуны хурдан морины бүсийн уралдааны хуваарь

№	Уралдааны нэр	Уралдах нас	Хугацаа	Зохион байгуулагч сум, холбоо
Хаврын уралдаан /5-р сар/				
1	“Эг-Үүрийн хурд” аймгийн зүүн бүсийн уралдаан	Бага 3, Сонгомол 2 нас	5-р сарын 05 өдөр	Эрдэнэбулган сумын МСУХ
2	Аймгийн баруун бүсийн хурд Арбулаг	Бага 3, Сонгомол 2 нас	5 сарын 05 өдөр	Арбулаг сумын МСУХ
3	Шишгэд хурд	Дээд 3 нас, Сонгомол дээд нас	5 сарын 05	Ринчинлхүмбэ сумын Батцагаан хүлэг МСУХ
4	Тэсийн хурд” аймгийн баруун бүсийн уралдаан	6 нас/Азарга Их нас, соёолон бага 3/	5 сарын 10	Цэцэрлэг сумын Тэсийн хишиг МСУХ
5	“Дэлтэй Цэнхэрийн хурд” төвийн бүсийн уралдаан	Бага 3 нас, Сонгомол 2 нас	5-р сарын 1 нд	Мөрөн, Дэлтэй Цэнхэр МСУХ
Аймгийн бүсийн зуны уралдаанууд				
1	Аймгийн зүүн бүсийн уралдаан Рашаант хурд	Дээд 3 Сонгомол дээд	7- сарын 1 нд	Рашаант сумын Булган уул МСУХ
2	Аймгийн баруун бүсийн уралдаан	Дээд 3 Сонгомол дээд	7-сарын 1 нд	Цагаан-Уул сумын Хотгойд 3 саарал МСУХ
3	Аймгийн урд бүс Идэрийн бүсийн хурд.	Дээд 3, Сонгомол дээд	6-р сарын 23 нд	Төмөрбулаг сумын МСУХ
4	Аймгийн хойд бүсийн уралдаан/Чандмань бүс/	Бага 3 нас	7-р сард	Ханх сумын Баясгалант хурд МСУХ
5	Аймгийн зүүн бүс	Дээд 3 Сонгомол дээд	6-р сарын 23 нд	Их-Уул сумын ИХ-Уулын хүлэг МСУХ

_____oOo_____

Аймгийн Засаг даргын 2024 оны
04 дүгээр сарын 30-ны өдрийн 1/20 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт

ХУРДАН МОРИНЫ УРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: М.Хуягбаатар-(Аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүдэд:Р.Машбат -(Хууль эрх зүйн хэлтсийн дарга)

Г.Оюунжаргал - (Нэгдсэн эмнэлгийн захирал)

Я.Эрхэмбаяр - (Хүнс хөдөө аж ахуйн газрын дарга)

А.Алтанцоож - (Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа)

Б.Баасансүрэн - (Хилийн цэргийн 0257-р ангийн дарга)

Ч.Дашбаяр - (Хүүхэд гэр бүлийн, хөгжил хамгааллын газрын дарга)

Ж.Даваадамдин - (Хөгжимт драмын театрын дарга)

Ц.Зоригт - (Хот тохижилт үйлчилгээний төвийн дарга)

Ч.Мөнх-Эрдэнэ - (Мал эмнэлгийн газрын албаны дарга)

Н.Билэгдэмбэрэл-(Хүнс хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн)

Г.Батболд - (Дэлтэй цэнхэр уяачдын холбооны тэргүүн)

Т.Наранхүү - (Дэлтэй цэнхэр уяачдын холбооны нарийн бичгийн дарга)

Нарийн бичгийн дарга: П.Эрдэнэсайхан -(Хүнс хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн)

----------oOo----------